



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

20/9 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Г Т  
Төрийн албаны зөвлөлийн  
салбар зөвлөл байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5, 5.6, 5.7, 5.11, 5.12 дахь заалт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.8, 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэд дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Салбар зөвлөлийн  
дарга:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал.

Гишүүд:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн; Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Мөнхтөр;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Э.Батболд; Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Анхбаяр;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга М.Баяраа; Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналтшинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Г.Ганхүү;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Д.Лхамжав

Салбар зөвлөлийн  
нарийн бичгийн дарга

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах шинжээч Ш.Уранчимэг.

ТАЗ тогтоол 2019

2. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл байгуулснаас бусад харьяа байгууллагын хүний нөөцийн асуудлыг тус салбар зөвлөлд хариуцуулахаар тогтоосугай.

3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга /Г.Нандинжаргал/-д даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишгийг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 203 дугаар тогтоол, “Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, ажил үүргийн хуваарь батлах тухай” Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамын дэргэдэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны 19/01 дүгээр тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2016 оны 60 дугаар тушаал, “Төрийн албаны зөвлөлийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2018 оны 15 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ